# СҮХБААТАР ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ӨГӨӨЖ ЧИХЭР БООВ” ХХК“ХҮНСНИЙ ҮЙЛДВЭР” (ГУРИЛАН БҮТЭЭГДЭХҮҮН) ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР
2025

# БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## 1.1. Төслийн нэр

“Хүнсний үйлдвэр” (Гурилан бүтээгдэхүүн) төсөл

## 1.2. Төслийн зорилго

Бизнесийн цар хүрээ тэлж, томрохын хэрээр нийгэм, улс орныхоо өмнө хүлээх бидний үүрэг, хариуцлага улам бүр өндөрсөж, дэлхийн стандарт, дэвшилтэт техник, технологийг эх орондоо нэвтрүүлж, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.

## 1.3. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр

“Өгөөж Чихэр Боов” ХХК
Регистрийн дугаар: 2583569
Холбоо барих утас: 312100
Хаяг: Сүхбаатар дүүрэг 5-р хороо

## 1.4. Төслийн байршил

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 5-р хороо 2.3 га талбайд хэрэгждэг.



Зураг 1. Төслийн талбайн тойм зураг





Зураг 2. Төслийн барилга байгууламж

### 1.5. Түүхий эд

Стандартын шаардлага хангасан, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичигтэй түүхий эд материал үйлдвэрлэлд хүлээн авч хэрэглэдэг. Хүлээн авсан түүхий эд материалаа “Өгөөж-Чихэр Боов” ХХК-ийн Түүхий эд материалыг үйлдвэрлэлд хүлээн авч хадгалах ба үйлдвэрлэлд бэлтгэх технологийн зааврын дагуу бэлтгэдэг.

Хүснэгт 1. Түүхий эдийн жагсаалт

| Түүхий эдийн жагсаалт | | | |
|---|---|---|---|
| 1. | Гурил (улаан буудай) | 13. | Давс |
| 2. | Алтан тариан гурал (1,2,дээд гурил) | 14. | Хөөлгөгч |
| 3. | Бүхэл үрийн гурил | 15. | Сод |
| 4. | Хөх тарианы гурил | 16. | Жимсний чанамал (төрөл бүрээс) |
| 5. | Элсэн чихэр | 17. | Шанзны төрөл бүрээс<br>Ирис<br>Интоор<br>Нэрс |
| 6. | Элсэн чихрийн уусмал | 18. | Шоколад |
| 7. | Нунтаг элсэн чихэр | 19. | Үзэм |
| 8. | Бүх төрлийн элсэн чихэр | 20. | Самар |
| 9. | Ургамлын тос | 21. | Аарц |
| 10. | Далдуу модны тос | 22. | Сүү |
| 12. | Өрмөнцрийн тос | 23. | Нойтон өндөг |

### 1.6. Төслийн хүчин чадал

“Өгөөж Чихэр Боов” ХХК нь нарийн боов, жигнэмэг, талх, чихэр зэрэг нийт 130 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Компани нь нарийн боов үйлдвэрлэл, худалдаа гэсэн чиглэл үйл ажиллагаа явуулдаг. Нарийн боов, Чанах, Еэвэн мөөхий, Үрэл зөөлөн чихэр Өнхрүүш, Жигнэх, Вафли гэсэн цехүүдтэйгээр үйлдвэрлэлээ явуулдаг. Үйлдвэр нь хоногт 15-20тн нарийн боов, талх талхан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай.

## 1.7. Технологи

Хүнсний үйлдвэрийн технологи нь дараах зурагт үзүүлсэн схемийн дагуу явагдана.




## 1.8. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил

Төслийн талбай орчинд зам тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч, цахилгаан хангамж дэд бүтэц сайн хөгжсөн.

***Цахилгаан хангамж:*** Цахилгаан хангамжийн хувьд төвийн эрчим хүчний системд бүрэн холбогдсон.

***Дулаан хангамж:*** Төсөл нь төвийн дулаан хангамжид бүрэн холбогдсон.

***Цэвэр усны хангамж:*** Үйлдвэрийн хэрэглээний болон технологийн усан хангамжийг төвийн нэгдсэн системээс хангадаг.

***Харилцаа холбоо:*** Холбоо мэдээллийн хувьд бүх үүрэн телефон холбоо ашиглах боломжтой.

***Зам харилцаа:*** Төсөл хэрэгжих талбай нь Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 5-р хорооны нутагт байрлах тул төвийн хатуу хучилттай замтай холбогдсон.




Зураг 3. Төслийн талбай орчмын зам харилцаа

### 1.9. Цэвэр усны хэрэглээ

Тус хүнсний үйлдвэрлэл нь жилийн 4 улиралд тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд уг хүнсний үйлдвэрт нийт 350 ажилтан ажиллана. Үйлдвэр нь хоногт 15-20 тн нарийн боов, талх, талхан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай. Тус төслийн ус хэрэглээний цэвэр усны тооцоог БОНХАЖЯ-ны сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301 тоот “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-д заасан 14-р хавсралтын 24-д заасны дагуу тооцож гаргав.

Хүснэгт 2. Нийт усны хэрэглээ

| | Хүчин чадал | Усны хэрэглээ | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Норм | Хоногт/ $м^3$/ | Сард /$м^3$/ | Жилд /$м^3$/ |
| Технологийн хэрэгцээнд | 20 тн | 3.2 $м^3$ | 64 | 1910 | 23040 |
| Ажилчдын унд ахуйн хэрэгцээнд | 350 хүн | 0.08 $м^3$ | 28 | 840 | 10080 |
| Нийт | | 3.28 | 92 | 2760 | 33120 |

*1 сарыг 30 хоног, 1 жилийг 360 хоногоор тооцов.*

### 1.10. Үйлдвэрлэлийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгдэх стандарт

1. “Өгөөж-Чихэр боов” ХХК-ийн Хөдөлмөрийн дотоод журам
2. Түүхий эд материал тус бүрийн Техникийн шаардлага
3. Компанийн батлагдсан жор, технологийн заавар бүтээгдэхүүн тус бүрээр
4. Өгөөж-Чихэр боов” ХХК-ийн “Түүхий эд материалыг үйлдвэрлэлд хүлээн авч хадгалах ба үйлдвэрлэлд бэлтгэх” технологийн заавар
5. Хүнсний тухай хууль
6. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль
7. Эрүүл ахуйн тухай хууль
8. Хог, хаягдлын тухай хууль
9. Гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас №8.7.1
10. Гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн эрүүл ахуйн орчин нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудас №10.11.6
11. Жигнэмэл гурилан бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага MNS 2488:2021
12. Чаналгын гурилан бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага MNS 4578:2021
13. Талх, талхан бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага MNS 4661:2009
14. Бялуун төрлийн бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага MNS 0464:2010
15. Өрмөнцөр. Техникийн ерөнхий шаардлага MNS 0635:2022
16. Үрлэн чихэр. Техникийн ерөнхий шаардлага MNS 0439:2021
17. Монгол үндэстний тавгийн идээний боов. Техникийн ерөнхий шаардлага MNS 0461:2022
18. Жигнэмэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 0158:2022
19. Бүржмэл чихэр. Техникийн ерөнхий шаардлага MNS 0443-97
20. Зөөлөн чихэр. Техникийн ерөнхий шаардлага MNS 4661-2009
21. Ундны ус “MNS 0900: 2021-ын стандартын шаардлага
22. “Өгөөж-Чихэр боов” ХХК-ийн Үйлдвэрийн ариун цэвэр, эрүүл ахуй, халдваргүйтгэл мэрэгчгүйтгэлийн журам.
23. “Өгөөж-Чихэр боов” ХХК-ийн Үйлдвэрлэл технологийн нэгжийн үйл ажиллагааны журам
24. Дотоод хяналт мониторингийн журам
25. Зах зээлээс шаардлага хангахгүй бүтээгдэхүүнийг буцаан татан авах журам
26. Ул мөр мөшгин тогтоох журам
27. Савласан хүнсний бүтээгдэхүүний шошгололтонд тавих ерөнхий шаардлага MNS 6648:2016
28. Хүнсний технологи. Хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үр тарианы цавуулаг багатай бүтээгдэхүүн. MNS CAC 118 : 1999
29. Худалдааны агуулахын стандарт MNS 5364:2011

# 2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

## 2.1. Төслийн гол сөрөг нөлөөллийг тодорхойлох

“Өгөөж Чихэр Боов” ХХК-ийн “Хүнсний үйлдвэр”(Гурилан бүтээгдэхүүн)” төслөөс хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлсон үр дүнд үндэслэн нөлөөллийн эх үүсвэр, шинж чанарыг тодорхойлж дараах хүснэгтэд үзүүлэв.

Өмнө нь хийгдсэн болзошгүй нөлөөллийн судалгааны дүнгээс үзвэл төслөөс байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь:

1. Хаягдал бохир усыг зайлуулах технологийн горимыг баримтлаагүй тохиолдолд газрын гүний болон хөрсний ус бохирдож улмаар гадаргын усны чанарт сөргөөр нөлөөлөх.
2. Хатуу хог хаягдлыг цуглуулах, зайлуулах журам, дэглэм, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хөрс болон агаар орчныг бохирдуулах.
3. Машин тээврийн хэрэгсэл, хөдөлгөөн ихсэх, олон салаа зам гаргах зэргээс хөрс элэгдэл эвдрэлд орох, дагтарших.
4. Хүний хөдөлгөөн ихсэх, түр хугацааны зам жим гарах, анхаарал болгоомжгүйгээс ой хээрийн түймэр гарах зэрэг нь ургамлан бүрхүүлд нөлөөлөн, түүний төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж /хогийн ургамал ихсэх/, ургац муудах магадлалтай.

Хүснэгт 2. Гол сөрөг нөлөөлөл ба эх үүсвэр

| № | Нөлөөлөл | Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа) | Нөлөөллийн шинж чанар |
|---|---|---|---|
| Агаар орчин | | | |
| 1 | Тоосжилт | - Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн | - Тархах хүрээ хязгаарлагдмал.<br>- Амархан сарнина. |
| 2 | Утаа,<br>Угаар | - Тээврийн хэрэгсэл | - Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал. |
| Усан орчин | | | |
| 3 | Хатуу болон шингэн хаягдал | - Ахуйн хог хаягдал<br>- Шатах тослох материалын хаягдал<br>- Бохир ус дамжуулах шугам хоолойн гэмтэл | - Гадаргын ус бохирдоно.<br>-Хөрс болон хөрсний ус бохирдох магадлалтай.<br>- Удаан сарнина. |
| 4 | Усны нөөцийн хомсдол | - Унд ахуйн усны хэрэглээ | - Нөхөн сэргээх боломж бага, хугацаа удаан. |
| Хөрсөн бүрхэвч | | | |
| 5 | Элэгдэл, эвдрэл | - Зориулалтын бус замаар явснаар явган хүний зам жим гарах, хөрс дагтарших, талхлагдах | - Тархалтын хүрээ хязгаарлагдмал.<br>- Тархалтыг хязгаарлах боломжтой.<br>- Ямар нэг хэмжээгээр нөхөн сэргээх боломжтой.<br>- Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөгдөнө. |
| 6 | Бохирдол | - Ахуйн хог хаягдал<br>- Шингэн хог хаягдал<br>- Шатах тослох материалын асгаралт<br>- Бохир ус дамжуулах шугам хоолойн гэмтэл | - Тархах хүрээ хязгаарлагдмал.<br>- Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар алдагдана. |
| Ургамал бүрхэвч | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | Ургамлан нөмрөг талхлагдах | - Хүний хөл хөдөлгөөн, үйл ажиллагаанд байнга өртөж буй зам, жим<br>- Ашиглалтын талбай, барилга байгууламжийн орчим | - Хэмжээ хязгаарлагдмал.<br>- Тухайн орчны ургамлан нөмрөг багасах, төрөл зүйл хомсдох<br>- Ургамлын төрөл зүйл устаж болно.<br>- Ургамалжуулалт хийснээр нөхөн сэргээх боломжтой.<br>- Хүчтэй нөлөөлбөл ургамлыг нөхөн сэргээхэд бэрхшээлтэй болж болно. |
| 8 | Хордох | - Ахуйн хог болон шатах тослох материалын хаягдал | - Ургамлын биомассын хэмжээ багасна.<br>- Ургамлын бүрэлдэхүүнд өөрчлөлт орж болзошгүй.<br>- Ургамлан бүрхэвч эргэлт буцалтгүй устаж болно. |
| Амьтан | | | |
| 9 | Үргэн, дайжих | - Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн<br>- Дуу чимээ | Тухайн орчинд амьдрах боломжгүй болж дайжих |
| 10 | Хордох | - Хог хаягдал<br>- Шатах тослох материалын асгаралт | - Тархалтын хүрээ хязгаарлагдмал<br>- Хөрсөн дэх бичил биетэн, шавж хорхой үрэгдэж болно.<br>- Ашиггүй бичил биетэн үржих.<br>- Амьтдын удамшил генд өөрчлөлт орох магадлалтай. |
| Нийгэм-эдийн засгийн орчин | | | |
| 11 | Хүнсний үйлдвэрлэл | - Хүн амын хүнсний хэрэглээг хангах. | Хүн амын амьдрах нөхцөлд эерэг нөлөө гарна. |
| 12 | Үндсэн хөрөнгө | - Татварын эх үүсвэр | Төсөвт хувь нэмэр оруулна. |
| 13 | Шинэ ажиллагсад авна. | - Ажлын байр шинээр бий болно. | Иргэд орлогын тогтмол эх үүсвэртэй болно. |

## 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

***Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт:***

“Өгөөж Чихэр Боов” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Хүнсний үйлдвэр” (Гурилан бүтээгдэхүүн ) төслийн үйл ажиллагааг явуулахдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- Байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, журам заавар, стандартын шаардлагад нийцүүлэн төслийн үйл ажиллагааг явуулна.
- Байгаль орчны менежментийн асуудлаар БОННҮ-ний тайланд боловсруулан тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ.
- Ажилчид байгаль орчны хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа ойлгосон байх, сургаалтанд хамрагдах боломжтой болно.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилсан тооцсоноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг хадгалж, хамгаална.
- Дүүрэг хорооны удирдлага, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний саналыг авч хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.
- Агааржуулалтын тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн ажиллагааг байнга анхаарч, засвар үйлчилгээ, шинэчлэлийг тухай бүрд нь хийж байх;
- Үйлдвэрийн байрын тоосжилт, чимээ шуугиан, чийгшил, гэрэлтүүлгийн байдалд хяналт шинжилгээ хийлгэх;
- Үйлдвэрийн орчны шаардлагатай зам талбайг хатуу хучилттай болгох;
- Хогийн цэгийн байгууламжийг өндөрлөх, засвар үйлчилгээ хийх;
- Орчны болон ажлын байрны хөрсний бохирдлын байдалд шинжилгээ хийлгэх;
- Ус хэрэглээний нормыг цех бүр дээр нарийвчлан хянаж, усыг ариг гамтай, үр ашигтай зарцуулах;
- Үйлдвэрээс гарч буй бохир усны найрлагыг ЗДХ-тэй харьцуулах шинжилгээг УСУГ-ын ТЦБАлбаны бохир усны сорилын лабораториор хийлгэх;
- Бүх ажилчдыг жилд 1 удаа эрүүл мэндийн нэгдсэн үзлэг, шинжилгээнд хамруулах;
- Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах;
- Үйлдвэрийн ажлын байранд мэргэжлийн хяналтын байгууллагаар ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд эрүүл ахуйн хэмжилт хийлгэх, дүгнэлт гаргуулах;
- Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж энэ чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам гаргах;
- Байгаль орчныг хамгаалах асуудлаарх жилийн тайлангаа орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь гаргаж өгч байх;

- Бохир усыг дахин ашиглах технологийг нэвтрүүлэх /зөвлөмжийн дагуу/;

### 3.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Өгөөж Чихэр Боов” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний тайланг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОАЖЯ-наас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагуудтай уялдуулан боловсруулсан ба тэдгээрийн хэрэгжилтийг 5 жилийн хугацаанд буюу 2021 оноос 2025 оны хугацаанд төлөвлөсөн. Байгаль орчныг хамгаалах ажил нь ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй.

БОХТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 12 сарын 10-ний дотор БОАЖЯ-нд ирүүлж, мөн орон нутгийн засаг захиргааны байгууллага, хорооны иргэдэд танилцуулж, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах нь зүйтэй.

#### 3.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Сүхбаатар дүүргийн 5-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Өгөөж Чихэр Боов” ХХК-ийн “Хүнсний үйлдвэр”(Гурилан бүтээгдэхүүн) төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага эрчимтэй боловч байгалийн хам бүрдэлд үзүүлэх нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх арилгах, бууруулах үүднээс төслийг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай ба байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу тухайн жилийн байгаль менежментийн төлөвлөгөөний тайланг хийв.

## 3.1.2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, өртөгч | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ (5 жилээр) | Нэгж зардал (.төг) | Нийт зардал (.төг) | Хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ** | | | | | | | | | |
| Хийн хаягдал, Тоосжилт | Орчны агаараас сорьц дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлуулан, зааварзөвлөмж авч ажиллах | Агаарын чанар | жилд 1 удаа | ОХШХ-т тусгагдсан. | | “Өгөөж Чихэр Боов” ХХК | Мэргэжлийн байгууллага, судлаач | Шинжилгээний дүн | Үйлдвэрлэлийн орчин болон гадна орчноос агаарын шинжилгээг мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораториар шинжлүүлэв<br>Agaariin shinjilgee hariu 2025.08.25 toc<br>Agaariin shinjilgeenii hariu 2 |
| **Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ** | | | | | | | | | |
| Усны нөөц, хэрэглээ | Ус ашигласны төлбөрийг тооцож төлөх | Төслийн хүрээнд | Жил бүр | Үйл ажиллагааны зардалд тусгагдсан. | | “Өгөөж Чихэр Боов” ХХК | | Худгийн тоолуурын заалтаар ус хэрэглээг тооцдог байх | Ус ашигласан төлбөрийг сар бүр УСУГ-д төлж байна. |
| | Ус хэмнэх төхөөрөмжийг үйлчилгээндээ ашиглах /ус хэмнэгч хошуу/ | Ариун цэврийн өрөө | | 40.000 | 40.000 | “Өгөөж Чихэр Боов” ХХК | Нийлүүлэгч байгууллага | | Үйлдвэрлэлийн ариун цэврийн өрөөнүүдэд ус хэмнэлтийн холигч нийт 8 ш байруулсан. |
| **Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, газрын гадаргад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ** | | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ургамлан нөмрөг талхлагдах, хөрсөн бүрхэвч бохирдох | Төсөл хэрэгжих талбай, хашаанаас гадна хог хаягдал хаяхгүй, газрын гадарга, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэрэгжүүлж байх | Ойр орчмын хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг | Тогтмол | Үйл ажиллагааны зардалд тусгагдсан. | “Өгөөж Чихэр Боов” ХХК | | | Төслийн нийт талбайн 2,944.18 м.кв талбайд ногоон байгууламжтай хөрсийг сийрэгжүүлэх ба тэгшлэх ажил хөрс хамгаалах ажил, хог ургамлыг устгах ажил хийсэн. |
| **Амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ** | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | **40.000** | | | | |

### 3.1.3. АЖИЛЧДЫН ЭРҮҮЛ МЭНДЭД УЧРУУЛАХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ | | | | | | | | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бүх ажиллагсдыг мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хугацаат эрүүл мэндийн үзлэгт хамруулах | Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах | Жилд 1 удаа | 350 ажилчин /1 удаа | 20.0 | 2.500.000 | “Өгөөж Чихэр Боов” ХХК | Мэргэжлийн байгууллага | Бүх ажиллагсдыг мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон 6 сар тутам эрүүл мэндийн хугацаат үзлэгт гэрээт эмнэлэгүүдээр гэрээ байгуулан үзүүлж байна. */ Гэрээнүүдийг хавсралт 1-ээр үзүүлэв./* |
| Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сурталчилгаар тогтмол хийж байх, “Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-тай ажилчид танилцаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшүүлэх | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа | Өдөр бүр | - | - | Зардал тусгах шаардлагагүй | “Өгөөж Чихэр Боов” ХХК | ХАБ ажилтан | Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сурталчилгаар тогтмол хийж байх, “Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-тай ажилчид танилцаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшүүлж ажиллаж байна. |
| Үйлдвэрийн ажилчдад өглөө бүр аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч гарын үсэг зуруулан баталгаажуулж ажилтныг аюулгүй ажиллах арга барилд байнга сургаж байх | Аюулгүй ажиллагаа | Өдөр бүр | - | - | Зардал тусгах шаардлагагүй | “Өгөөж Чихэр Боов” ХХК | ХАБ ажилтан | Үйлдвэрийн ажилчдад өглөө бүр аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч гарын үсэг зуруулан баталгаажуулж ажилтныг аюулгүй ажиллах арга барилыг хэрэгжүүлж ажиллаж байна. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ MNS 5080:2001” стандартыг мөрдөж ажиллах. | Хөдөлмөрийн аюулгүй байдал | Тогтмол | - | - | Зардал тусгах шаардлагагүй | “Өгөөж Чихэр Боов” ХХК | ХАБ ажилтан | Үйлдвэрлэлийн хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг бүх ажлын байран дээр 2024 онд хийлгэсэн. 2025 онд Лаборатори болон Еэвэн мөөхий цех дээр хийлгэхээр компанийн төсөвд тусгасан. |
| **Нийт: 2,500,000** | | | | | | | | |

### 3.1.4. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

<table>
<tr><th>Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт</th><th>Нөхөн сэргээлтийн арга хэмжээ</th><th>Арга хэмжээний цар хүрээ</th><th>Хэмжих нэгж</th><th>Тоо хэмжээ</th><th>Нэгжийн зардал, төг</th><th>Нийт зардал, төг</th><th>Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж</th><th>Биелэлт</th></tr>
<tr><td rowspan="2">Элэгдэл эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээн, ногоон байгууламж бий болгох</td><td rowspan="2">Орчны тохижилтыг сайжруулан, төслийн талбайд ногоон байгууламж хийх</td><td>Хайлаас</td><td>Ширхэг</td><td>25</td><td>4500</td><td>112,500</td><td rowspan="2"></td><td rowspan="5">Үйлдвэрэлийн ногоон бүсэд 25 ш мод шинээр тарьж, Ногоон байгууламжаа зүлэгжүүлсэн.</td></tr>
<tr><td>Нийт</td><td></td><td></td><td></td><td>112,500</td></tr>
<tr><td colspan="2" rowspan="2">Ногоон байгууламж байгуулах зардал</td><td colspan="4">Арготехникийн ажиллагаа</td><td>200.000</td><td rowspan="2"></td></tr>
<tr><td colspan="4">Ажилчдын хөлс</td><td>-</td></tr>
<tr><td>Арчилгаа, тордлогоо</td><td>Ногоон байгууламжийн усалгаа тайралт, хэлбэржүүлэлт хийх</td><td colspan="4">Төслийн талбайд</td><td>-</td><td>Төсөл хэрэгжих хугацаанд</td></tr>
<tr><td colspan="9">Нийт дүн 312.500</td></tr>
</table>

## 3.1.5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, өртөгч | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ (5 жилээр) | Нэгж зардал (.төг) | Нийт зардал (.төг) | Хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө** | | | | | | | | | |
| **Хог хаягдлыг дахин боловсруулах, цэвэрлэх** | Хог хаягдлын менежментийг сайжруулах, дахин боловсруулалтыг нэмэгдүүлэх ажилд нэгдэж хог хаягдал, хуванцар савыг дахин боловсруулах аж ахуй нэгж байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан үйлдвэрээс болон, ажилчдын хэрэглээнээс гарч буй хог хаягдлыг нийлүүлж байх | Удирдлагын түвшинд | Удаа | - | - | "Өгөөж Чихэр Боов" ХХК | Гэрээ байгуулж ажиллах | Хамтран ажиллах гэрээ | Хог хаягдлын цэгийг 3-н хэсэгт хуваарж үйлдвэрлэл болон оффисоос гарсан хог хаягдлыг гэрээт компаниар ачуулж байна. / Хавсралт-2 үзүүлэв/ |
| | Бэлэн бүтээгдэхүүн савласан сав баглаа боодлыг эргүүлэн татан хаягдал сав баглааг дахин боловсруулах | Төслийн хүрээнд | Тогтмол | - | - | "Өгөөж Чихэр Боов" ХХК | Гэрээ байгуулах, олон нийтийн сүлжээгээр мэдээлэл түгээх | Гэрээ, дахин боловсруулан мэдээлэл | Үйлдвэрлэлээс гарч байгаа картон цаас болон бэлэн бүтээгдэхүүний хаягдлыг гэрээт компанид нийлүүлдэг. */ Гэрээнүүдийг хавсралт 3-д үзүүлэв./* |
| | Гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зуурмаг бэлдэх, чанах, жигнэх тогооны цэвэрлэгээнээс гарах тосны хаягдлыг төвийн бохирын шугамд нийлүүлэхээс өмнө хаягдал тосыг шүүх механик төхөөрөмжийг ашиглах | Төслийн хүрээнд | Удаа | - | 250.000 | "Өгөөж Чихэр Боов" ХХК | Тоног тахаармж | - | Үйлдвэрлэлийн угаалтуурын бүрийн төгсгөлд тос баригч төхөөрөмжүүдийг суурилуулж, тогтмол цэвэрлэгээ ариутгал хийлгэж байна. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хуванцар савыг ангилан ялгах зориулалтын хогийн савыг байршуулахыг зөвлөж байна. | Үйлдвэрийн хашаанд | 1 Удаа | - | 400.000 | “Өгөөж Чихэр Боов” ХХК | Ангилдаг хогийн сав худалддаг ААН | | Үйлдвэрлэлийн хашаан дотор болон гадна талбайд |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Удаан задардаг хатуу хог хаягдал үүсэх | Үйлдвэрийн талбай дахь хог хаягдлыг цэвэрлэж, эдэлбэр газрын ашиглалтыг сайжруулах | Үйлдвэрийн хашаанд | 1 удаа | - | 60.0 | “Өгөөж Чихэр Боов” ХХК | | Талбайн зохион байгуулалт | 3-н шатлалт хогийн савнуудыг байрлуулав. |
| | Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх | Төслийн хүрээнд | Тухай бүрт нь | - | Зардал тусгах шаардлага гүй. | “Өгөөж Чихэр Боов” ХХК | Гэрээ байгуулж ажиллах | | Картон цаасаа гэрээтээр нийлүүлж байна. |
| Ялаа шавж үржих, өвчин гарах | Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх | Хатуу хог хаягдлын цэгт | 7 хоногт 1 удаа | Зардал тусгах шаардлагагүй | | “Өгөөж Чихэр Боов” ХХК | | | Гэрээт компани болон эрүүл ахуйч нар хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйтгэл хийлгэдэг. |
| Ахуйн хатуу хог хаягдал орчныг бохирдуулах | Хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт тээвэрлүүлж байх | Төслийн хүрээнд | Тогтмол | Холбогдох байгууллагатай хийсэн гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр. | | Өгөөж Чихэр Боов” ХХК | | Хог хаягдлын гэрээ | Хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд гэрээт компаниар тээвэрлүүлдэг. |
| **Нийт-710.000** | | | | | | | | | |

## 3.1.6. УДИРДЛАГА-ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, өртөгч | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ (5 жилээр) | Нэгж зардал (.төг) | Нийт зардал (.төг) | Хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Байгаль орчны удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээ** | | | | | | | | | |
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж жил бүр батлуулж байх | | Төслийн хүрээнд | Жил бүр | - | | “Өгөөж Чихэр Боов” ХХК | | БОМТ-ний тайлан | 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан БОУАӨЯ-р батлуулсан. |
| Ажилчдын дунд байгаль хамгаалах талаар сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах<br>- Байгаль орчныг хамгаалах<br>- Гал түймрээс урьдчилан сэргийлэх /шаардлагатай үед гал унтраах багаж хэрэгслийг ашиглаж чаддаг байх/<br>- Хөдөлмөр хамгаалал<br>- Тогтвортой хөгжлийн зорилтуудыг танилцуулах зэрэг сэдвээр | | Бүх ажилчид | Жилд 1 удаа | 100.0 | 100.0 | “Өгөөж Чихэр Боов” ХХК | Байгаль орчны мэргэжилтний оролцоотойгоор | Сургаалтанд хамрагдсан бүртгэл тэмдэглэл | СБД-ийн онцгой байдлын хэлтэстэй хамтран Галын аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулав. / *Хавсралт 4-д үзүүлэв/* |
| Газар, ус, цахилгаан ашигласны болон бусад төлбөрийг төлөх | | Төсөвт хувь нэмэр оруулах | 5 багц | Үйл ажиллагааны зардалд тусгагдана. | | “Өгөөж Чихэр Боов” ХХК | - | Төлбөр төлсөн баримт | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу сар бүр төлж байгаа. |
| Эрүүл мэндийг хамгаалах | Ажлын байранд эмийн сан бий болгох | Иж бүрэн | 1 | 80.0 | 80.0 | “Өгөөж Чихэр Боов” ХХК | - | Зургаар баримтжуулах | Алба нэгж бүрт анхны тусламжийн хайрцагтай ХАБЭАА-наас сар бүртгэл хөтлөн хяналт хийн ажиллаж байна. |
| | Үйлдвэрийн гадна орчны тохижилтод анхааран гэрэлтүүлэг хийх | Иж бүрэн | 1 | 300.0 | 300.0 | “Өгөөж Чихэр Боов” ХХК | - | | Үйлдвэрлэлийн хашаан дотор нийт 10 ширхэг гэрэлтүүлэг хийв. |
| Дүүргийн байгаль хамгаалах албатай хамтран байгаль хамгааллын систем байгуулан ажиллах | Төслийн үйл ажиллагаатай холбогдуулан дүүргийн болон хорооны холбогдох төр захиргааны байгууллагатай хамтран ажиллах | Иж бүрэн | 1 | Тухайн үеийн үйл ажиллагааны зардалд тусгагдана. | | “Өгөөж Чихэр Боов” ХХК | Дүүрэг | Хамран ажиллах баримт | СБД-ийн 5-р хороотой хамтран нийтийн зам талбайн цэвэрлэгээг хийв. |
| **Нийт- 480.0** | | | | | | | | | |

## 3.1.7. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд** | **Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр** | **Мэдээллийн агуулга** | **Хугацааны тов** | **Хэлэлцүүлгээр санал авах чиглэл** | **Зохион байгуулах газар** | **Хэрэгжүүлэгч** | |
| Дүүргийн байгаль орчны газар | Шинжээчдийн дүгнэлтээр баталгаажна. | Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан | Жил бүрийн 11-р сарын 1 | Шинжээчдийн дүгнэлт | Дүүргийн байгаль орчны газар | Өгөөж Чихэр Боов" ХХК | 2025 онд БОМТ-ын төлөвлөгөө гаргаж батлуулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийн 2025.11.01-ний дотор БОУАӨЯ-рүү илгээв. |
| Бүх шатны Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн байцаагч | Хуралд танилцуулах, Уулзалт | БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө | 12-р сарын 1-ний дотор | БОХ арга хэмжээний тайлан ирэх оны төлөвлөгөөг танилцуулах, санал авах, хамтран ажиллах | Дүүрэг, хороо | Өгөөж Чихэр Боов" ХХК | |
| Төрийн бус байгууллага, олон нийт | | | Жил бүр 1 удаа | | Тухайн үед сонгох | Өгөөж Чихэр Боов" ХХК | |
| Төрийн захиргааны төв байгууллага | Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр | | 12-р сарын 10-ний дотор | Хянуулах батлуулах | Улаанбаатар хот | Өгөөж Чихэр Боов" ХХК | |

## 3.2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Өгөөж Чихэр Боов” ХХК-ийн “Хүнсний үйлдвэр”(Гурилан бүтээгдэхүүн) үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамруулан байгаль орчны хяналт шинжилгээний мониторингийн системийг байгуулах нь зүйтэй.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” /ОХШХ/ гэнэ. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.




Зураг 4. Орчны хяналт шинжилгээний цэгүүд

***Агаар орчин***

ОХШХ-т тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж, дүгнэлт гаргуулж байх, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авна. Хийн бохирдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амрагч сувилуулагч, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байх ёстой буюу төлөвлөлтийн холбогдох үндсэн шалгуурууд агаарт хаяж буй бохирдуулагчдад тавигдах ёстой.

***Усны чанар***

Усны чанарын шинжилгээг төсөл хэрэгжих хугацаанд хийлгэх хяналт шинжилгээг графикт хугацаанд нь шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан, бохирдол илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран түүнийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай..

***Хөрсөн бүрхэвч***

Хөрсний бохирдлын түвшинг дотоодын магадлан итгэмжлэгдсэн лабораториор гүйцэтгүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрт тогтоосон сорьц авах цэгүүд дээр үргэлжлүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж дүгнэлт гаргуулж байх.

Хүснэгт 3. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт | Хэмжих нэгж | Байршил | Хугацаа ба давтамж | Нэгж зардал (мян.төг) | Нийт зардал (мян.төг) | Хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч | Баримтлах стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. АГААРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ | | | | | | | | | |
| 1.1. | Хорт хийн агууламж: Азотын давхар исэл ($NO_2$) Хүхэрлэг хий ($SO_2$) Нүүрстөрөгчийн дутуу исэл ($CO_2$), CO, HCN, $O_2$. | мкг/м$^3$ | Хатуу хог хаягдлын цэгийн ойролцоо болон ногоон байгууламжийн ойролцоо 1 цэг | Жилд 1 удаа (7 сард) | 400.0 | 400.0 | “Өгөөж Чихэр Боов” ХХК | Мэргэжлийн байгууллага, судлаач | MNS 4585:2016<br>MNS 3384:1982<br>MNS 4048:1988<br>MNS 0017-2-5-11:1988<br>MNS 5013:2009<br>MNS 5014:2009<br>MNS 5002:2000 |
| 1.2. | Агаарын тоос тоосонцор ($PM_{2.5}$, $PM_{10}$) | мкм | Бохирдол үүсэх эх үүсвэр орчимд 1 цэгээс дээж авах | | | | | | |
| 2. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ | | | | | | | | | |
| 2.1. | Усны химийн шинжилгээ | мг/дм$^3$<br>1 мл-т илрүүлэх 100 мл-т | Үйлдвэрийн хэрэглээний усны их үүсвэрээс | Жилд 1 удаа | 100.0 | 100.0 | Өгөөж Чихэр Боов” ХХК | Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн усны лаборатори, Ус цаг уур орчны шинжилгээний газар | MNS (ISO) 5667-1:2002<br>MNS (ISO) 5667-2:2002:<br>MNS 4867-1999:<br>УСТ-3534-1983<br>MNS 0900:2005<br>MNS 4685:1998 |
| ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ | | | | | | | | | |
| 3.1. | Хөрсний физик, агрохимийн үндсэн үзүүлэлтүүд: Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент ($NO_3$, $P_2O_5$, $K_2O$) | мг | Ногоон байгууламжийн ойролцоо | Жилд 1 удаа | - | 100.0 | Өгөөж Чихэр Боов” ХХК | Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн Хөрс судлалын лабораытори, Магадлан итгэмжлэгдсэн хөрсний лабораториуд | MNS 3298:1991<br>MNS 5850:2008<br>MNS 3985-87<br>MNS 3310-91<br>MNS 2305-94<br>MNS 2305:1994 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2. | Хөрсний хүнд элементүүд /Pb, Cr, Cd, Ni, Co/ | | Хатуу хог хаягдлын цэг эсвэл авто зогсоолын ойролцоо | Жилд 2 удаа | - | 200.0 | Өгөөж Чихэр Боов” ХХК | | |
| ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ | | | | | | | | | |
| 4.1 | Дуу шуугиан | дБА | Үйлдвэрийн талбай орчимд | Жилд 1 удаа | - | 400.0 | Өгөөж Чихэр Боов” ХХК | Хорооны эрүүл мэндийн байгууллага | MNS 5002:2000<br>MNS ISO 226:2003 |
| 1 жилийн ОХШХ-ийн нийт зардал /мян.төг/ | | | | | | 1200.0 | | | |

**Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний 2025 оны зардлыг дараах хүснэгтэд харуулав.**

| **Зардлын хэлбэр** | Нийт зардал, төг |
|---|---|
| Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал | 40.000 |
| Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө | 312.500 |
| Ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ | 2.500.000 |
| Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал | 710.000 |
| Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ | 480.000 |
| Орчны хяналт шинжилгээний зардал | 1.200.000 |
| **Нийт** | **5.242.000** |

*“Өгөөж Чихэр Боов” ХХК-ийн “Хүнсний үйлдвэр” төс “Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал* **5.242.500** *(таван сая хоёр зуун дөчин хоёр мянга таван зуу) төгрөг болж байна.*

# БҮЛЭГ 1. ГОЛ ҮР ДҮНГҮҮД БА НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлэх бөгөөд төслийг хэрэгжүүлэгч “Өгөөж Чихэр Боов” ХХК ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллана.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОУАӨЯ-наас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагуудтай уялдуулан боловсруулсан.

2021 онд хийгдсэн БОННҮ-ний тайланд тусгасан төслийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОМТ)-ийн дагуу тухайн жилийн БОМТ-г хууль, журмын дагуу шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамжийг 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж өгөв.

“Өгөөж Чихэр Боов” ХХК-ийн “Хүнсний үйлдвэр” (Гурилан бүтээгдэхүүн) төсөл нь Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 5-р хороо 2.3 га талбайд хэрэгждэг. Төслийг хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа явуулж буй “Өгөөж Чихэр Боов” ХХК нь тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **5.242.500** ба үүнд 2025 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал багтсан болно.

**Төлөвлөгөөний биелэлтийн хавсралтууд:**
**Хавсралт-1 Урьдчилан сэргийлэх үзлэгийн гэрээнүүд**

БАТЛАВ
"ЮНИМЕД ИНТЕРНЕЙШНЛ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
ЗАХИРАЛ
С.БУЯНТ

БАТЛАВ
"ӨГӨӨЖ ЧИХЭР БООВ" ХХК
ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
ЗАХИРАЛ
Х.БААСАНДОРЖ

**УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГИЙН ГЭРЭЭ**

2025 оны 09 сарын 08 өдөр № 2025/05 Улаанбаатар хот

**Нэг. Гэрээний нөхцөл**

Нэг талаас магадлан итгэмжлэгдсэн "ЮНИМЕД ИНТЕРНЕЙШНЛ" ХХК-ийг төлөөлж Амбулаторийн менежер Ж.Эрдэнэчимэг /цаашид эмнэлэг/, нөгөө талаас "ӨГӨӨЖ ЧИХЭР БООВ" ХХК-ийг төлөөлж Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежер С.Чоймаа /цаашид үйлчлүүлэгч/, хамтад нь /талууд гэх/ нар нь харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

**Хоёр. Гэрээний зорилго**

2.1 Үйлчлүүлэгч байгууллагын ажилтан, албан хаагчдад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг тохирсон багцийн дагуу эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой /цаашид "Үйлчилгээ гэх/ холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

2.2 Энэхүү гэрээний хугацаа нь Үйлчлүүлэгч байгууллагат харьяалагддаг ажилтан, албан тушаалтан, албан хаагчид нь Эмнэлгээс үйлчилгээ авч дуусах хүртэлх хугацаанд хүчинтэй байна.

2.3 Үйлчилгээнд хамрагдах хугацаа: 2025 оны 09 сарын 05-ний өдрөөс урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг дуусах хүртэл үргэлжилнэ. Үзлэг шинжилгээний хуваарийг хавсралтын дагуу хийж гүйцэтгэнэ. /Хавсралт 02/

**Гурав. Эмнэлгийн хүлээх эрх, үүрэг**

3.1 Эмнэлэг нь тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдад хуваарийн дагуу урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг хийнэ.

3.2 Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ хариуцсан эмнэлгийн хэрэгсэл болон эмнэлгийн эрүүл ахуй, халдварын эсрэг дэглэм баримтлан үйлчилнэ.

3.3 Уг гэрээнд заасанаас бусад тохиолдолд нэмэлт шинжилгээнд хамрагдвал эмнэлгийн мөрддөг үнэ тарифаар үйлчилнэ.

3.4 Юнимед Интернейшнл эмнэлгийн "Нэгдсэн лаборатори" нь гадаад дотоодын чанарын хяналтанд тогтмол хамрагддаг бөгөөд олон улсын чанарын стандартыг хангасан шинжилгээний баталгаат хариу гаргаж өгнө.

3.5 Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан үйлчлүүлэгч байгууллагын ажилчдад эрүүл мэндийн зөвлөгөө, сургалтыг зохион байгуулж болно.

**Дөрөв. Үйлчлүүлэгч талын хүлээх эрх, үүрэг**

4.1 Өөрийн байгууллагын ажилтан, албан хаагчдаа урьдчилан сэргийлэх үзлэгт хуваарийн дагуу бүрэн хамруулна.

**Хавсралт-2 Хог хаягдал цуглуулах болон тээвэрлэх гэрээ.**

БАТЛАВ.
СҮХБААТАР ДҮҮРГИЙН
МЕНЕЖЕР [signature] Э.ЧИНЗОРИГ

## ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2025 оны 9 дугаар сарын 24-ны өдөр Улаанбаатар хот

| | | | |
|---|---|---|---|
| Иргэн, ААНБ-ын нэр | Өгөөж ЧБ ХХК | | |
| Регистрийн дугаар | 2583569. | | |
| Үйл ажиллагаа явуулж буй объектын оноосон нэр | Өгөөж хүнсний үйлдвэр. | | |
| Үйл ажиллагааны чиглэл | үйлдвэрлэл. | | |
| Иргэн, ААНБ-ын хаяг | СБД-5-р хороо | | |
| Иргэн, ААНБ-ын холбогдох утас | 99226080. | | |
| Газар зүйн хязгаарлалт | Сүхбаатар дүүргийн 5..-р хороо | | |
| Данс | **Худалдаа Хөгжлийн Банк 2611180719** | | |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төрөл | Айл өрхийн тоо .... Сард 2 удаа төгрөг | Сард 1100000 төгрөг | Рейсийн тоогоор 1 рейс ................ төгрөг |
| Төлбөрийн нөхцөл | Нийслэлийн Сүхбаатар Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 8/39 тоот тогтоолоор батлагдсан төлбөрийн хэмжээгээр 1100000 ............ төгрөгийг сар бүрийн .................. -ний өдрийн дотор **Худалдаа Хөгжлийн Банкны 2611180719** тоот дансанд бүрэн төлнө. | | |
| Гэрээний хугацаа | 2025 оны 9 сарын 24-ны өдрөөс 2025 оны 12 сарын 31-ны өдөр хүртэл | | |
| Гэрээний сунгалт | | | |
| Гэрээний нэмэлт өөрчлөлт | | | |

Энэхүү гэрээ нь Монгол Улсын "Хог хаягдлын тухай хууль", Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан "Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд мөрдөх журам", Сүхбаатар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдөр 8/39 тоот тогтоолоор батлагдсан "Үйлчилгээний төлбөрийн хураамж, тарифын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоол, Сүхбаатар Дүүргийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан хог тээврийн гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн баримтална.

Нэг талаас Сүхбаатар дүүргийн "Сүхбаатар дэвшил" ОНӨААТҮГ /цаашид "Хог хаягдал тээвэрлэгч" гэх/, түүнийг төлөөлж Сүхбаатар дүүргийн 5.......-р хорооны хураамж төвлөрүүлэлтийн байцаагч ажилтан ...байцаагч...-ийн .........Б............. /би/, нөгөө талаас Цэрэнханд ..........................
/иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нэр/

түүнийг төлөөлж /цаашид "Хог хаягдал тээвэрлүүлэгч" гэх/ .............................. ажилтай ..........................................-ийн ................................ /би/ бид нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.



250155

**Хавсралт-3 Бэлэн бүтээгдэхүүн савласан сав баглаа боодлыг эргүүлэн татан хаягдал сав баглааг дахин боловсруулах хаягдал цаас нийлүүлэх гэрээ**

БАТЛАВ.
" ӨГӨӨЖ-ЧИХЭР БООВ " ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
/.................../ Т.ГЭРЭЛТУЯА

БАТЛАВ.
"ЭКО ЦААС" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
/.................../ Ч.МЯНГАНБАЯР

**ХАЯГДАЛ ЦААС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

2025 оны 08 сарын 08-ны өдөр №25/03 Улаанбаатар хот

Энэхүү "Ажил гүйцэтгэх гэрээ" (цаашид "Гэрээ" гэх)-ийг Монгол улсын Иргэний хуулийн нийтлэг үндэслэл, 31 дүгээр бүлэг болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн, Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор болон бодитой биелүүлэх зарчмыг удирдлага болгон нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Регистрийн 2583569 тоот дугаартай "Өгөөж-Чихэр боов" (цаашид "**Худалдагч**" гэх)-ийг төлөөлж, Үйл ажиллагаа хариуцсан захирал Х.Балсанлорж болон, нөгөө талаас 6416845 Регистрийн тоот дугаартай "ЭКО ЦААС" ХХК-ийг төлөөлж ахлах нягтлан бодогч Б.Цэрэнханд (цаашид "**Захиалагч**" гэх) нар доор дурдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Гэрээгээр худалдагч нь Гэрээний 1-р зүйлийн 1.2 дахь хэсэгт заасан бүтээгдэхүүн (цаашид "**Гэрээний зүйл**" гэх)-ийг Гэрээгээр тохирсон нөхцөл болон Захиалагчийн шалгуур, шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх, Захиалагч нь Гэрээт ажлын төлбөр төлөхөөр Гэрээнд заасан нөхцлийн дагуу төлөх харилцаатай холбогдуулж Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, харилцан хүлээх хариуцлага болон Гэрээний хугацаа, үнэ, цуцлах нөхцөлтэй холбогдох харилцааг зохицуулна.

1.2. Гэрээний зүйл нь дараах хүснэгтэд заасан техникийн тодорхойлолт болон тоо хэмжээгээр тодорхойлогдоно. Үүнд:

| *Цаасны төрөл* | *Сард нийлүүлэх хаягдал цаас* | *Нэгж үнэ / 1 тонн* |
|---|---|---|
| Бор хайрцагны хаягдал цаас | 3 тн | 100,000 |

1.3 Захиалагч тал нь бараа хүлээн авахдаа хэмийн хорогдол тооцож авна. Хэмийн хорогдол тооцохдоо 10%-15% иар тооцно.

1.4 Энэхүү гэрээ нь талуудын хооронд гэрээ байгуулахаас өмнө үүссэн бүх харилцаа, тохиролцоог эрэмбэлэн баримт бичиг бөгөөд талууд шаардлагатай тохиолдолд харилцан тохиролцсоноор нэмэлт гэрээ байгуулж болно.

**Хоёр. Гэрээний хугацаа, гэрээний зүйлийг**
**Нийлүүлэх нөхцөл**

2.1 Гэрээний хугацаа нь Гэрээний зүйлийг Талууд бүрэн хүлээлцэх 2026 оны 08-р сарын 25-ны өдрийг хүртэл хугацаагаар тодорхойлогдох бөгөөд гэрээ нь Худалдагчийн гэрээгээр хүлээсэн үүргээ Захиалагчийн шаардлагад бүрэн нийцүүлэн гүйцэтгэж дуусах хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.

2.2 Цаашид хамтран ажиллах гэрээнд хоёр талаас нэмэлтээр санал хүсэлт гарах бол автоматаар гурван удаа нэг жилийн хугацаатай сунгаад ажиллаж болно.

**Хавсралт-4 СБД-ийн онцгой байдлын хэлтэстэй хамтран Галын аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулав.**

БАТЛАВ.
"ӨГӨӨЖ-ЧИХЭР БООВ" ХХК-ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
ЗАХИРАЛ
Х. Баасандорж

**КОМПАНИЙН НИЙТ АЖИЛТНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Сургалтын зорилго:**

Ажилтан ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ерөнхий ур чадварыг дээшлүүлэх, чиглүүлэх зорилготой нийт ажилтны сургалт 2025 оны 06 дугаар сарын 20-ны Баасан гарагийн 08 цагт дараах сэдвийн хүрээнд зохион байгуулагдана.

**Сургалт явагдах хугацаа:**

2025 оны 06 дугаар сарын 20 -ны өдөр 08:00-09:00, 60 минут танхимын хэлбэрээр зохион байгуулагдана. Нийт ажилтнуудыг идэвхтэй оролцуулахад алба нэгжийн дарга нар анхаарна уу.

| № | Сургалтын сэдэв | Сургалтын агуулга | Сургалт явуулах ЧҮН, Комисс | Сургалт явуулах ажилтан | Сургалтанд хамрагдах ЧҮН |
|---|---|---|---|---|---|
| 1 | Сургалтын нээлт | Нийт ажилтны сургалтыг нээн компанийн уриа, сургалтанд дэгтэй байхыг анхааруулна | МА | С. Сувдмаа | Нийт ажилтан |
| 2 | Галын аюулгүй байдал | Галын аюулгүй байдал | СБД-ийн Онцгой байдлын албан хаагч | | Нийт ажилтан |

СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН: ХНМ
Т.Дуламжав

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС**

**ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ БАТАЛГААНЫ ХУУДАС**

| Сургалт зохион байгуулсан албан тушаалтны өгөх мэдээлэл | | |
|---|---|---|
| Сургалтын ангилал | Сэдэв | Сургалт зохион байгуулсан алба хаагч |
| ☐ Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль<br>☐ Гамшгаас хамгаалах команд штабын сургууль<br>☐ Иргэд<br>☐ Оюутан<br>☐ Сурагч<br>☐ СӨБ<br>☐ Ажилтан, алба хаагч<br>☐ Удирдах бүрэлдэхүүн<br>☐ Алба, Мэргэжлийн анги<br>☐ Цэргийн дүйцүүлэх албаны сургалт<br>☐ Сайн дурын бүлэг, нөхөрлөл сургалт<br>☐ Хөгжлийн бэрхшээлтэй иргэд<br>Тайлбар: Энэ хэсгээс хэд хэдийг сонгож болох бөгөөд сонголт тус бүрийн ард сургалтад хамрагдсан хүний тоог тавина. | Галын аюулгүй байдал. | |
| Сургалтын төрөл:<br>☑ Танхим<br>☐ Дадлага<br>☐ Хосолсон<br>☐ Цахим<br>☐ Видео<br>☐ Дууриалган үзүүлэх | Сургалт зохион байгуулсан огноо:<br>2025 он 06 сар 20 өдөр | Сургалт зохион байгуулсан хугацаа:<br>08 цаг<br>60 минут |
| Хамрагдсан хүний тоо: Эр:........ Эм:................ Нийт:........... | | |
| Байгууллагын нэр:<br>"Өгөөж - Чихэр Боов" ХХК | Байршил:<br>СБД 5-р хороо Соёл гудамж - 35 | Үйл ажиллагааны чиглэл:<br>Хүнсний үйлдвэрлэл |
| Сургалтын талаарх санал, дүгнэлт: | Үнэлгээ:<br>☑ Бүрэн хангалттай<br>☐ Хангалттай<br>☐ Хангалтгүй<br>Тайлбар: | |

АЛБАН ТУШААЛ: ЧАХ 3, Baasandorj /

Тэмдэг, гарын үсэг, гарын үсгийн тайлал

**Хавсралт-5 Үйлдвэрлэлийн ногоон байгууламжийн цэцэрлэгжүүлтийн ажил хийв.**







**Хавсралт 5: Хөрсний шинжилгээний хариу**

MNAS Accreditation system
TL 185
MNS ISO/IEC 17025

"ДЭЭЖ" ХӨРС СУДЛАЛ, УСНЫ СОРИЛТЫН ЛАБОРАТОРИ
Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 27 р хороо, 35 р байр 1 тоот
Холбогдох дугаар: 976 88000776, E-mail:deejhors.2022@gmail.com

## "ДЭЭЖ" ХӨРС СУДЛАЛ, УСНЫ СОРИЛТЫН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

**Дээжийн бүртгэлийн дугаар: 25/06-18/2201-2202**
**Захиалагч: "Өгөөж чихэр боов" ХХК**
**Дээж авсан цэг: 2201-Ногоон байгууламж 4 цэг, 2202-Хогийн цэгийн хажууд тал**
**Холбоо барих дугаар: 99160201 88081259**

| Дээжийн тодорхойлолт | | | | |
|---|---|---|---|---|
| Дээжийн дугаар | Дээжийн нэр | Хүлээн авсан хугацаа | Шинжилсэн хугацаа | Олгосон Огноо |
| 6-18/2201 | Хөрс | 2025.06.18 | 2025.06.19 | 2025.06.27 |

| I. Хөрсний химийн үндсэн үзүүлэлтүүд | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дээжийн дугаар | Шинжилгээний аргын стандарт | Дээж авсан гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, ds/m | Ялзмаг, % | $CaCO_3$, % | Солилцох суурьууд, мг-экв/100г | | Шим тэжээлийн элементүүд, мг/100г | |
| | | | | | | | | $Ca^{+2}$ | $Mg^{+2}$ | $P_2O_5$ | $K_2O$ |
| 6-18/2201 | MNS 3310:1991 | 0-30 | 7.89 | 0.05 | 0.289 | 2.43 | - | 19 | 15 | 2.0 | 23 |

| II. Хөрсний механик бүрэлдэхүүн | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дээжийн дугаар | Шинжилгээний аргын стандарт | Дээж авсан гүн, см | Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
| | | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 6-18/2201 | MNS 6824:2020 | 0-30 | 27.9 | 49.3 | 17.9 | 8.8 | 4.1 | 2.0 | 14.9 |

| III. Хөрсний хүнд металлын үзүүлэлтүүд | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дээжийн дугаар | Шинжилгээний аргын стандарт | Дээж авсан гүн, см | Хөрсний хүнд металлын агууламж, мг/кг | | | | | |
| | | | Cr /хром/ | Pb /хар тугалага/ | Cd /кадми/ | Zn /цайр/ | Cu /зэс/ | Ni /никель/ |
| 6-18/2202 | MNS ISO 11466:2007 | 0-15 | 28.7 | 38.7 | - | 25.8 | 21.9 | 30.1 |
| Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019 | | | | | | | | |
| **Элсэрхэг хөрс** | | | **60** | **50** | **1** | **100** | **60** | **60** |
| Шаврандцар хөрс | | | 100 | 70 | 1.5 | 150 | 80 | 100 |
| Шаварлаг хөрс | | | 150 | 100 | 3 | 300 | 100 | 150 |

Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хувилан олшруулахыг хориглоно.

Сорилтыг гүйцэтгэсэн:
Шинжээч Г.Сувдмаа

баталгаажуулсан:
Лабораторийн эрхлэгч Д.Золзаяа, M.Sc

MNAS
Accreditation system
TL 185
MNS ISO/IEC 17025

"ДЭЭЖ" ХӨРС СУДЛАЛ, УСНЫ СОРИЛТЫН ЛАБОРАТОРИ
Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 27 р хороо, 39 р байр 1 тоот
Холбогдох дугаар: 976 88000776, E-mail:deejhors.2022@gmail.com

# "ДЭЭЖ" ХӨРС СУДЛАЛ, УСНЫ СОРИЛТЫН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

**Дээжийн бүртгэлийн дугаар: 25/09-16/3357**
**Захиалагч: "Өгөөж чихэр боов" ХХК**
**Дээж авсан цэг: СБД 5-р хороо**
**Холбоо барих дугаар: 99160201**

| **Дээжийн тодорхойлолт** | | | | |
|---|---|---|---|---|
| Дээжийн дугаар | Дээжийн нэр | Хүлээн авсан хугацаа | Шинжилсэн хугацаа | Олгосон Огноо |
| 09-16/3357 | Хөрс | 2025.09.16 | 2025.09.17 | 2025.09.30 |

**I. Хөрсний механик бүрэлдэхүүн**

| Дээжийн цэг | Шинжилгээний аргын стандарт | Дээж авсан гүн, см | Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 09-16/3357 | MNS 6824:2020 | 0-12 | 29.1 | 41.7 | 15.4 | 7.4 | 4.6 | 1.8 | 13.8 |

**II. Хөрсний хүнд металлын үзүүлэлтүүд**

| Дээжийн цэг | Шинжилгээний аргын стандарт | Дээж авсан гүн, см | Хөрсний хүнд металлын агууламж, мг/кг | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Cd /кадми/ | Cr /хром/ | Ni /никель/ | Pb /хар тугалага/ | Zn /цайр/ | Cu /зэс/ |
| 09-16/3357 | MNS ISO 11466:2007 | 0-12 | - | 26.9 | 29.5 | 35.2 | 27.4 | 19.7 |
| **Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019** | | | | | | | | |
| **Элсэрхэг хөрс** | | | **1** | **60** | **60** | **50** | **100** | **60** |
| Шаврансар хөрс | | | 1.5 | 100 | 100 | 70 | 150 | 80 |
| Шаварлаг хөрс | | | 3 | 150 | 150 | 100 | 300 | 100 |

Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хувилан олшруулахыг хориглоно.

Сорилтыг гүйцэтгэсэн:
Шинжээч Б.Хуслэн

баталгаажуулсан:
Лабораторийн эрхлэгч Д.Золзаяа, M.Sc

ГОЛОМТ БАНК
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

# Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: S91322611202504103

Татсан огноо: 2025-04-10 16:22

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| **1102759613**<br>MN760015001102759613 | **100900013406** | **2,621,000.00 MNT** | **Амжилттай** |

Шилжүүлэгчийн нэр
**ӨГӨӨЖ ЧИХЭР БООВ ХК**

Хүлээн авагчийн нэр
**БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА**

Гүйлгээний утга
**БАЙГАЛВ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ЗАРДАЛ ӨГӨӨ Ж ЧБ**

Хүлээн авагчийн банк
**Төрийн сан**

Гүйлгээний огноо
**2025-04-10**

ГОЛОМТ БАНК 01 ХУУЛБАР ҮНЭН

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©, Голомтбанк ХК.